


Мэдээлэл болон боловсролын үйлчилгээ үзүүлэх RSBP платформ www.rsbp-mn.org

Энэхүү Мэдлэг Хуваалцах Цахим Индэрээр дамжуулан Жижиг Дунд Бизнесийн Бүс Нутгийн Хөтөлбөр (RSBP) нь бичил, жижиг дунд бизнест санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй санхүүгийн байгууллагуудад салбарын экспертүүдийн мэдлэгээс хуваалцах, сургалтын үйл ажиллагаанд хамрагдах боломжийг олгох юм.



 БЖДБ-ийн санхүүжилтийн талаарх өргөн хүрээний сэдвийг хамран төрөл бүрийн хэлбэрээр явагдах **Сургалт**ын үйл ажиллагаанд хамрагдах боломжийг олгоно.

Оролцогч санхүүгийн байгууллагууд дараах хэлбэрээр явагдах сургалтад хамрагдах боломжтой.



Танхимын сургалт

Зорилтот сургалт,
семинар, лекц



Цахим сургалт

Бие даан суралцах
цахим сургалтууд



Хосолсон сургалт

Практик хэрэглээг
хослуулсан танхимын
болон цахим сургалт



Сертификат олгох сургалт

БЖДБ-ийн санхүүжилтийн
талаарх мэдлэг, ур
чадварыг цахим
хэлбэрээр баталгаажуулах

Санхүүгийн байгууллагуудыг төлөөлөн ажиллаж буй ажилтнуудаар дамжуулан ирүүлсэн өргөдлийг хүлээн авч танхимын сургалтыг зохион байгуулж оролцуулах боломжтой.


Хөтөлбөрт оролцогч санхүүгийн байгууллагуудаас тодорхойлолт гаргах боломжтой эсвэл тухайн байгууллагын цахим хаягт үндэслэн автоматаар ажилтнуудад нэвтрэх эрх олгон сургах сургалт.

Нэвтрэх эрх олгох алхам:

1. Бүртгэл
2. Идэвхжүүлэлт
3. Цахим сургалтад бүртгүүлэх

Энэхүү хосолсон сургалт нь туршлагажсан эсвэл дунд буюу түүнээс дээш шатны албан тушаал хашиж буй ажилтнуудад зориулагдсан.

БЖДБ-ийн санхүүжилтийн талаарх мэдлэг болон ур чадварыг баталгаажуулах зорилготой санхүүгийн байгууллагын ажил мэргэжлийн хувьд ялгаатай ажилтнуудад чиглэсэн сургалт юм

 **RSBP-ийн Номын Сан** – БЖДБ үйлчилгээ үзүүлж санхүүжүүлэхтэй холбоотой сэдвийн хүрээнд нийтлэгдсэн төрөл бүрийн нийтлэл, судалгааны ажлууд болон тайлан зэргийг агуулсан.

RSBP Номын сан хүн бүрд нээлттэй.



БЖДБ-ийн санхүүжилт

БЖДБ үйлчилгээ үзүүлэх, болон санхүүжүүлэхтэй холбоотой нийтлэлүүд болон бусад материалууд




Боловсон хүчин

Ажиллах хүчийг хөгжүүлэх, сургахтай холбоотой бичиг баримт болон бусад материалууд



Арга зүй ба хэрэгслүүд

БЖДБ үйлчилгээ үзүүлэх болон санхүүжүүлэхтэй холбоотой тэргүүн туршлага болон арга зүйг түлхүү агуулсан бичиг баримт, зааварчилгаа

 **KWS хэлэлцүүлэг өрнүүлэх форум** – энэ нь БЖДБ-ийн санхүүжилттэй холбоотой сэдвүүдээр мэргэжилтнүүд, хамтран ажиллагчид болон салбарын ажилтнууд өөр хоорондоо санал бодол солилцох, мэдлэг туршлага болон тэргүүний арга барилуудыг хуваалцах боломжийг олгодог энэхүү платформын тусгай хэсэг юм.



KWS нь салбарт хэлэлцэгдэж буй “голлох” сэдвүүдийн хүрээнд ажлын хэсэг байгуулах боломжийг мөн бүрдүүлнэ. Тухайн хэлэлцүүлгийн үр дүнгээс хамааран хэлэлцүүлгийн үр дүнг нийтлэл байдлаар хэвлэх, эсвэл цахим болон танхимын сургалтын материал болгон хөгжүүлэх боломжтой.

KWS нь оролцогч санхүүгийн байгууллагын удирдлага болон гол экспертүүдэд нээлттэй байна.

RSBP мэдээлэл түгээх, мэдлэг хуваалцах үйлчилгээг санхүүгийн байгууллагын сургалттай хэрхэн уялдуулах вэ?

- Өөрийн байгууллагын ажилтнуудад RSBP-ийн платформ (www.rsbp-mn.org)-д нэвтрэх боломжийг бүрдүүлсэн байх.
- Нэг болон хэд хэдэн ажилтныг хөтөлбөртэй холбоо тогтоон, хамтран ажиллах боломжтой байхаар зохион байгуулах.
- Өөрийн байгууллагын сургалтын хөтөлбөрт RSBP-ийн танхимын болон цахим сургалтын үйлчилгээг уялдуулах
- RSBP-тэй хамтран сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах зэрэг болно.

